

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/150 дугаар захирамжийг үндэслэн дор дурдсан байршилд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр /интернетээр/ зохион байгуулахаар зарлаж байна.

1. Дуудлага худалдааны хэлбэр: Цахим хэлбэрээр /Интернетээр/ Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу дараах 1 байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа явагдана.
 - I. Баянтал сумын 1 дүгээр багт, 152 дугаар байрны зүүн талд байрлах 0,022 га /220м²/ газрыг Автомашины гаражийн зориулалтаар
2. Эзэмшүүлэх хугацаа: 15 жил /арван таван/
3. Анхны үнэ: 1-р байршил 176,000 /зуун далан зургаан мянга/ төгрөг
4. Дэнчин: 1-р байршил 17,600 /арван долоон мянга зургаан зуун/ төгрөгийг 100220008402 дансанд тушааж баримтыг хавсаргана.
5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамж буюу 12500 төгрөгийг 100220400941 дансанд тушааж баримтыг хавсаргасан байх.
6. Гэрээний зүйл: Баянтал сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасны дагуу ашиглахтай холбогдсон зураг төслийг газар эзэмших гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор багтаан боловсруулж ирүүлнэ.
7. Цахим хуудас: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар найдвартай сүлжээний доголдолгүй газраас нэвтэрч оролцоно.
8. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа: Дуудлага худалдаанд оролцогчдыг 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 08 цаг 30 минутаас эхлэн 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 15 цаг 00 минут хүртэл зөвхөн ажлын өдрүүдэд, ажлын цагаар /08:30-17:30/ бүртгэж, баталгаажуулна.
9. Дуудлага худалдаа эхлэх: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 09:00 цагаас эхлэнэ.
10. Дуудлага худалдаа явагдах хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 09:00 цагаас эхлэн 15:00 цаг хүртэл тасралтгүй үргэлжилнэ.
11. Дуудлага худалдааны ялагчийг тодруулах журам: Дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогч ялагч болох бөгөөд ялагч нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь ирүүлж, дэнчин болон улсын тэмдэгтийн хураамжийг бүрэн төлсөн, өөрийн мэдээллээ үнэн зөв гаргасан, дуудлага худалдааны дэг журмыг зөрчөөгүй байна.
12. Газрын байршил, хил хязгаарын зураг схем:

1-р байршил

X= 293704.53 Y= 5160712.38
X= 293710.48 Y= 5160685.20
X= 293718.19 Y= 5160686.81
X= 293712.32 Y= 5160714.00
X= 293704.53 Y= 5160712.38



Дуудлага худалдаа явуулах газрын байршил, хил хязгаар, заагийг харуулсан зураг, схем, бусад дэлгэрэнгүй мэдээллийг АЗДТГ-ын 109 тоот өрөөнд өгч байна.

Жич: Дуудлага худалдаанд оролцогч нь Газрын цахим биржийн www.mle.mn сайтын талаар болон Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт зэрэгтэй урьдчилан сайтар танилцах шаардлагатай.

Лавлах утас: 70543387, 99180283